

МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛИЙН БАКАЛАВРЫН ОРОЙ, ЭЧНЭЭ ХӨТӨЛБӨРТ 2012 ОНД ОЮУТАН ЭЛСҮҮЛЭХ ЖУРАМ¹

1. Ерөнхий зүйл

- 1.1. Бакалаврын зэрэгтэй иргэнийг МУИС-ийн бакалаврын орой, эчнээ хөтөлбөрт зарим мэргэжлээр элсүүлэхэд БСШУ-ны сайдын 2005/422, 2006/483 тоот тушаалаар баталсан “Оюутан элсүүлэх үлгэрчилсэн журам” болон энэхүү журмыг баримтална.
- 1.2. МУИС-ийн бакалаврын орой, эчнээ хөтөлбөрт элсэхээр бүртгүүлэгч, элсэгч болон элсэлтийн комиссын үйл ажиллагааг зохицуулахад энэ журмын зорилго оршино.
- 1.3. МУИС-ийн бакалаврын орой, эчнээ хөтөлбөрт элсэхээр хүсэлт гаргасан иргэнийг “бүртгүүлэгч”, зохих болзол хангаж элсэлтийн хяналтын тоонд багтсан бүртгүүлэгчийг “элсэгч”, элсэлтийн цахим бүртгэлийн системийг “систем” гэнэ. Элсэлтийн үйл ажиллагааг нэгдсэн байдлаар зохион байгуулахаар томилогдсон комиссыг “элсэлтийн комисс”, элсэлтийн үйл ажиллагааг зохион байгуулахад оролцох ажилтныг “комиссын гишүүн” гэнэ.
- 1.4. МУИС-ийн бакалаврын орой, эчнээ хөтөлбөрт элсүүлэх оюутны хяналтын тоог БСШУЯ тогтооно.
- 1.5. Бүртгүүлэгч бүртгүүлэхээс өмнө энэхүү журамтай танилцах үүрэгтэй.
- 1.6. Энэхүү журам болон нэмэлт мэдээллийг <http://burtgel.num.edu.mn/docs/> цахим хуудсанд байрлуулна.
- 1.7. Элсэлтийн комиссын хаяг, хөтөлбөр, хуваарь сонгуулах өдөр, цаг, байр бусад мэдээллийг бүртгэлийн хугацаанд МУИС-ийн төв байрны гаднах электрон самбар болон систем, www.num.edu.mn цахим хуудсанд байрлуулна.
- 1.8. Энэхүү журмаар зохицуулагдахгүй асуудал гарвал МУИС-ийн Захирлын тушаалаар байгуулагдсан Элсэлтийн комисс шийдвэрлэнэ.

2. Бүртгүүлэгчдэд тавих шаардлага

- 2.1. МУИС-ийн бакалаврын орой, эчнээ хөтөлбөрт (хавсралтыг үз) бакалаврын зэрэгтэй иргэнийг элсүүлэх ба Ерөнхий шалгалт (ЕШ) өгсөн байхыг шаардахгүй.
- 2.2. Хавсралтад зааснаас бусад чиглэлээр хоёр дахь бакалаврын боловсрол эзэмших хүсэлтэй иргэн “МУИС-ийн бакалаврын хөтөлбөрт 2012 онд Улаанбаатар хотоос оюутан элсүүлэх журам”-ын дагуу элсэлтийн ЕШ өгч, элсэх болзол хангаж элсэнэ. Элссэний дараа өмнө нь бакалаврын зэрэг эзэмшихдээ амжилттай судалсан хичээлээсээ 60 хүртэл багц цагийг шилжүүлэн тооцуулах боломжтой.
- 2.3. Бүртгүүлэгч бүртгэлтэй холбоотой төлбөр тооцоог цахим хэлбэрээр хийнэ.
- 2.4. Бүртгүүлэгч нь элсэлттэй холбоотой мэдээллийг SMS-ээр хүлээн авах гар утасны дугаар, цахим шуудангийн хаягийг бүртгүүлнэ.

3. Элсэлтийн бүртгэл

- 3.1. Элсэлтийн бүртгэлийг зөвхөн цахим хэлбэрээр <http://burtgel.num.edu.mn> хаягаар явуулна.
- 3.2. Элсэлтийн бүртгэл дараах өдрүүдэд явагдана. Үүнд:
 - Эрх зүйн эчнээ хөтөлбөрийн бүртгэл: 2012 оны 3-р сарын 12-22
 - Бусад (эрх зүйгээс бусад) эчнээ хөтөлбөрийн бүртгэл: 2012 оны 9-р сарын 1-21

¹ МУИС-ийн Орхон, Завхан дахь бүрэлдэхүүн сургуулиуд орой, эчнээ хөтөлбөрийн элсэлтээ тухайн сургуулийн шийдвэрээр зохион байгуулна.

- Оройн хөтөлбөрүүдийн бүртгэл: 2012 оны 5-р сарын 25-наас 6-р сарын 15
- 3.3.Элсэлтийн тухай товч мэдээллийг бүртгэл эхлэхээс 2-оос доошгүй сарын өмнө олон нийтийн мэдээллийн хэрэгслээр зарлаж, МУИС-ийн болон бүрэлдэхүүн сургуулиудын цахим хуудас, мөн <http://burtgel.num.edu.mn> цахим хуудсанд байршуулна.
- 3.4.Элсэгч системд хувийн мэдээлэл болон системд нэвтрэх мэдээллээ (цахим шуудангийн хаяг, нэвтрэх үгээ) оруулснаар элсэх хүсэлтээ гаргана.
- 3.5.Бүртгүүлэхдээ бүртгэлийн анкет (тухайн үед тусгай маягтаар бүртгэнэ)-ыг бөглөж, дараах бичиг баримтуудын эх хувийг сканнердаж цахим хэлбэрээр хавсаргана. Үүнд:
 - Өмнө нь эзэмшсэн бакалаврын боловсролын диплом, тэдгээрийн хавсралт
 - Иргэний үнэмлэх
 - Цээж зураг (сүүлийн 3 сард авахуулсан, 3x4 хэмжээтэй байх)
 - Банкны цахим төлбөрийн системээр бүртгэл, шалгалтын хураамж төлнө (Голомт банк, Төрийн банк, Хас банк, Хадгаламж банк, Капитрон банкны төгрөгийн цахим гүйлгээ хийдэг, өөрийн эзэмшдэг эсвэл өөр эзэмшигчийн (эзэмшигчийн зөвшөөрлөөр) картаар төлбөр хийх боломжтой. Мөн Худалдаа хөгжлийн банк, ХААН банкнаас бусад банкны олон улсын эрхтэй картаар төлбөр хийж болно).
- 3.6.Бүртгүүлэгч хэдэн ч хөтөлбөрт бүртгүүлж болно. Хөтөлбөр бүрийн бүртгэл, шалгалтын хураамж нийлээд 6000 ₮ байна.
- 3.7.Бүртгүүлэхийг хүссэн хөтөлбөрийг сонгосон үед төлбөл зохих нийт төлбөрийн хэмжээ гарах бөгөөд уг мэдээлэлтэй танилцаж төлбөрийг цахим хэлбэрээр хийнэ.

4. Элсэлтийн шалгалт

- 4.1.Бүртгүүлэгч нь элсэхийг хүссэн хөтөлбөрт шаардлагатай хичээлээр зохих шалгалтыг өгнө. Шалгалт өгөх хичээлүүдийг хавсралтад заав.
- 4.2.Шалгалтыг бүртгэл дууссаны дараах долоо хоногт авах ба шалгалт авах өдөр, цагийг элсэлтийн бүртгэл эхлэхэд <http://burtgel.num.edu.mn> цахим хуудсанд байршуулсан байна.
- 4.3.Шалгалтанд авбал зохих нийт онооны 60-аас доошгүй хувийг авбал МУИС-д элсэх болзол хангасан гэж үзэх бөгөөд шалгалтанд авсан нийт оноог дараах байдлаар тодорхойно. Үүнд:
 - Тухайн хөтөлбөрийн хувьд нэг шалгалт авахаар байгаа бол уг шалгалтанд авсан оноо;
 - Тухайн хөтөлбөрийн хувьд хоёр шалгалт авах бол хоёр шалгалтын оноог 70:30 харьцаагаар тооцно. Өөрөөр хэлбэл, I шалгалтад авсан оноог 0.7-оор, II шалгалтад авсан оноог 0.3-аар үржүүлж нэмнэ.
- 4.4.Шалгуулагчдыг өгсөн шалгалтын нийт оноогоор (4.3-т заасан аргачлалаар тодорхойлсон) жагсааж, онооны дарааллаар хяналтын тоонд багтаан элсүүлнэ.
- 4.5.Хяналтын тоонд багтсан эсэхийг шалгалт дууссаны дараа тогтоосон хугацаанд системээр мэдэгдэнэ.

5. Элсэх эрх олгох

- 5.1.Хуваарь сонголт нэг өдөр үргэлжилнэ. Хуваарь сонгуулах өдрийн 09:00-13:00 цагийн хооронд хяналтын тоонд багтсан бүртгүүлэгчдэд элсэх эрх олгоно. Хяналтын тоонд багтсан ч өөр хөтөлбөр сонгосон хүнийг жагсаалтаас хасах бөгөөд дараагийн хүнд хяналтын тоонд багтсан гэсэн мэдэгдлийг SMS-ээр илгээнэ.
- 5.2.13:00 цагаас хойш хуваарь үлдвэл мөн өдрийн зарласан цагт бүртгүүлэгч өөрийн биеэр ирж онооныхоо жагсаалтын дарааллаар хуваарь сонгоно. Зарласан цагт нэрийг нь дуудахад байхгүй бол онооны дарааллаар дараагийн хүнд сонголтыг шилжүүлнэ. Хуваарь сонгох үед хоцорсон бүртгүүлэгч ирсэн даруй үлдсэн хуваариас онооны дарааллаар сонгох эрхтэй.
- 5.3.Бүртгүүлэгч хуваарь сонгохдоо дараах материалыг бүрдүүлнэ. Үүнд:

- i. Иргэний үнэмлэх эсвэл түүнтэй адилтгах баримт бичиг, хуулбарын (ар, өвөр тал нэг нүүрэнд) хамт
- ii. Өмнө нь эзэмшсэн боловсролын диплом, хавсралтын хамт
- iii. Цээж зураг 2 хувь, оюутны үнэмлэхний шаардлагад нийцсэн цээж зураг файл хэлбэрээр (аль аль нь сүүлийн 3 сард авахуулсан)

Эдгээр материалыг битүүмжлэл сайтай хавтсанд хийсэн байна.

5.4.Элсэх эрх олгох үед бүртгэлийн мэдээллийг эх бичиг баримтуудтай нь тулгаж баталгаажуулна.

6. Бусад

- 6.1.Элсэгч хуваарь буцаах тохиолдолд нэг багц цагийн үнэлгээний хэмжээний төлбөр төлнө.
- 6.2.Нэг хөтөлбөрөөс нөгөө хөтөлбөрт шилжүүлэн элсүүлэхгүй ба хуваарийг бусдад шилжүүлэхийг хориглоно.
- 6.3.Элсэгч бүртгүүлж, эхний улирлын сургалтын төлбөр төлсний дараа элссэн тушаалыг гаргах бөгөөд тушаал нь гарсан оюутнууд МУИС-ийн мэдээллийн системийг ашиглах хэрэглэгчийн нэр, нууц үгийг цахим шуудангаар хүлээн авна. Бүртгэлийн хугацааг хуваарь сонгох үед зарлана.
- 6.4.Элсэлттэй холбоотой бичиг баримтыг хуурамчаар үйлдсэн хүнийг МУИС-д элсүүлэхгүй, элссэн тохиолдолд хасна.
- 6.5.Элсэлтийг цахим хэлбэрээр явуулахад зориулсан цахим хуудас нь бүтэн жилийн турш тогтмол ажиллагаатай байж, элсэлтийн талаарх мэдээллээр бүртгүүлэгчдийг хангана.
- 6.6.Цахим бүртгэл явагдаж байх үед МУИС-ийн бүрэлдэхүүн сургуулиуд хөтөлбөрүүдээ танилцуулах, зөвлөгөө өгөх үйл ажиллагааг утас, мессенжер болон и-мэйлээр зохион байгуулна.

**МУИС-ийн бакалаврын орой, эчнээ хөтөлбөрт 2012 онд оюутан
элсүүлэх хөтөлбөр, авах шалгалт, нийт оноонд эзлэх харьцаа**

Бүрэлдэхүүн сургууль	Хөтөлбөр		Элсэлтийн шалгалт	
			I - 70%	II – 30%
Газар зүй, геологийн сургууль	Орой	Геологи	Математик	Газар зүй
	Эчнээ	Цаг уур	Математик	Физик
Математик, компьютерийн сургууль	Орой	Мэдээллийн технологи	Математик	
Хууль зүйн сургууль	Орой	Эрх зүй	Эрх зүйн ерөнхий мэдлэг	
	Эчнээ			
Эдийн засгийн сургууль	Орой	Нягтлан бодох бүртгэл	Математик	
		Санхүүгийн менежмент		
		Гадаад худалдаа, гаалийн менежмент		
		Маркетингийн менежмент		
	Эчнээ	Нягтлан бодох бүртгэл		
		Эдийн засаг, статистик		
		Гадаад худалдаа, гаалийн менежмент		
		Хүн ам зүй		
Гадаад хэл, соёлын сургууль	Орой	Англи хэлний багш	Англи хэл	
Нийгмийн шинжлэх ухааны сургууль	Эчнээ	Түүх, архив	Монголын түүх	
		Улс төр судлал	Улс төрийн шинжлэх ухааны үндэс	
Худалдааны сургууль	Орой	Нягтлан бодох бүртгэл (2.5 жил)	Математик	
		Нягтлан бодох бүртгэл (2 жил)		
	Эчнээ	Нягтлан бодох бүртгэл		